

**МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ ЗҮЙ ДОТООД ХЭРГИЙН САЙД,  
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2017 оны ..... дугаар  
сарын .....-ны өдөр

Дугаар .....

Улаанбаатар  
хот

Журам, загвар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шүүхийн захиргааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-ийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.“Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн мэдээллийн сан бүрдүүлэх, лавлагаа олгох журам”-ыг нэгдүгээр, “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тухай тэмдэглэл”-ийн загварыг хоёрдугаар, “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хуулийн этгээдийн тухай тэмдэглэл”-ийн загварыг гуравдугаар, “Шүүхийн мэдэгдэх хуудас”-ны загварыг дөрөвдүгээр, “Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас /хүн/”-ны загварыг тавдугаар, “Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас /хуулийн этгээд/”-ны загварыг зургаадугаар хавсралтаар, “Хүн, хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх лавлагааг албан бичгээр авах эрх бүхий байгууллагын жагсаалт”-ыг долоодугаар хавсралтаар, Хүний ял шийтгэлтэй байгаа эсэх “Тодорхойлолт”-ын загварыг наймдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, биелэлт, үр дүнг тооцож, ажиллахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргааны удирдлагын газрын дарга /Ж.Сайнхишиг/, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын дарга /цагдаагийн хурандаа О.Зоригт/, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны дарга /хурандаа С.Батсайхан/ нарт тус тус даалгасугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2008 оны хамтарсан 547, 494, А/113 тоот захирамж, тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалыг 2018 оны .. дугаар сарын ....-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

Н.ЛҮНДЭНДОРЖ

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн  
ерөнхий зөвлөлийн даргын 2017 оны  
..... дугаар хамтарсан  
тушаалын нэгдүгээр хавсралт

## **ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭСЭН ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, ЛАВЛАГАА ОЛГОХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэ журмын зорилго нь Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.10 дахь заалт болон 61 дүгээр зүйлийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангахын тулд эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн мэдээллийн цахим болон архивын сан /цаашид “Сан” гэх/ бүрдүүлэх, лавлагаа олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн мэдээллийг шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүлээн авч цахим болон архивын сан бүрдүүлэх ажлыг Цагдаагийн төв байгууллагын эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн мэдээллийн сан хариуцсан нэгж /цаашид “Мэдээллийн сан хариуцсан нэгж” гэх/ эрхлэн гүйцэтгэнэ.

1.3. Мэдээллийн сан хариуцсан нэгж нь хүн, хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан болон хүлээж байгаа эсэх лавлагааг олгоход Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 21-ний А/195 дугаар тушаалаар баталсан “Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, шинжлэн үнэлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа олгох журам” болон энэ журмыг баримтална.

1.4. Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн цахим мэдээллийн сан, түүний програм хангамж, “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тухай тэмдэглэл”, “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хуулийн этгээдийн тухай тэмдэглэл”, “Хорих ял эдэлсэн хүмүүсийн хувийн хэрэг” /цаашид “Ялтны хувийн хэрэг” гэх/, “Ялтны судалгааны карт”-ын архивын санг нууцлалын зэрэгт байлгаж, цахим мэдээллийн санд гадны хэрэглэгч нэвтрэх боломжгүй байхаар нууц түлхүүр үг хэрэглэнэ.

1.5. Сангийн мэдээлэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, нөхөх, хуулбарлах ажлыг зөвхөн Мэдээллийн сан хариуцсан нэгжийн эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр хийгдэж, тэмдэглэл үйлдэгдэнэ.

1.6. Сан бүрдүүлэх болон Лавлагаа олгохтой холбоотой санал, гомдлыг цагдаагийн төв байгууллагын Мэдээллийн сан хариуцсан нэгжийн эрх бүхий албан тушаалтан тухай бүр хянаж шийдвэрлэнэ.

**Хоёр. “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тухай тэмдэглэл”, “Эрүүгийн хариуцлага хүлээлсэн хуулийн этгээдийн тухай тэмдэглэл”, “Шүүхийн мэдэгдэх хуудас”-ыг хөтлөх, хүргүүлэх**

2.1. Мөрдөгч нь эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдсан хүн нэг бүрээр “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тухай тэмдэглэл”-ийг хөтлөх бөгөөд гэрэл /цээж/ зургийг нааж яллагдагчийн иргэний цахим үнэмлэх болон түүнтэй адилтгах бичиг баримтыг үндэслэн 1-8 дугаар асуултыг, яллагдагчаар татагдсан хуулийн этгээд нэг бүрээр “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хуулийн этгээдийн тухай тэмдэглэл”-ийг хөтлөх бөгөөд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, улсын бүртгэлийн байгууллагын лавлагаа зэргийг үндэслэн 1-11 дүгээр асуултыг тус тус гүйцэд, гаргацтай бөглөн албан тушаал, цол, эцэг /эх/-ийн нэрийн эхний үсэг болон өөрийн нэрийг бичиж, гарын үсэг зурна.

2.2 Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн тухай тэмдэглэлийг хөтлөхдөө архивын стандарт шаардлагыг хангасан А5 хэмжээтэй, 200 граммын “Матт” цаасан дээр үйлдсэн хэвлэмэл маягт дээр үйлдэнэ.

2.3. Яллагдагчаар татагдсан гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улсын хуулийн этгээдийн нэрийг “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн тухай тэмдэглэл”-д бичихдээ яллагдагчийн гадаад паспорт, хуулийн этгээдийн гэрчилгээ, түүнтэй адилтгах баримт бичиг дээрх гадаад буюу латин үсэг дээр бичигдсэн овог, нэр, байгууллагын нэрийг бичихийн зэрэгцээ кирил үсгээр хөрвүүлж бичнэ.

2.4. Гадаад нэртэй дотоодын хуулийн этгээдийн нэрийг “Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тэмдэглэл”-д бичихдээ улсын бүртгэлийн гэрчилгээ, лавлагаа, түүнтэй адилтгах баримт бичиг дээрх хөрвүүлгийг үндэслэн кирилл, латин үсгээр давхар бичнэ.

2.5. Шүүгчийн туслах нь “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тухай тэмдэглэл”-ийн маягтад тухайн хүний биеийн байцаалтыг үнэн, зөв хөтөлсөн эсэхийг магадлан, уг тэмдэглэлийн 9-13 дугаар асуултыг, “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хуулийн этгээдийн тухай тэмдэглэл”-ийн маягтад тухайн хуулийн этгээдийн мэдээллийг үнэн, зөв хөтөлсөн эсэхийг магадлан 12-16 дугаар асуултыг тус тус гүйцэд, гаргацтай бөглөж, Хэргийг шийдвэрлэсэн шүүгч, шүүх хуралдаан даргалагч нь мэдээллийн бодит байдлыг хянаж, эцэг /эх/-ийн нэрийн эхний үсэг болон өөрийн нэрийг бичиж, гарын үсэг зурна.

2.6. Анхан шатны шүүх нь эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн тухай тэмдэглэлийг шүүхийн шийтгэх тогтоол хүчинтэй болсон өдрөөс хойш, давж заалдах болон хяналтын шатны шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд шийдвэрийн заалтыг бүрэн тусгасан “Шүүхийн мэдэгдэх хуудас”-ыг батлагдсан маягтын дагуу бичиж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдоос дараагийн шатанд гомдол, хүсэлт гаргахаас үл хамааран ажлын 5 хоногт багтаан Мэдээллийн сан хариуцсан нэгжид хүргүүлнэ.

2.7. Лавлагааны сангийн эрх бүхий алба хаагч нь санд орсон эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн талаархи мэдээлэлд “Шүүхийн мэдэгдэх хуудас”-ыг үндэслэн тухай бүр баяжилт, хөдөлгөөн хийж байна.

2.8. “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тухай тэмдэглэл”, “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хуулийн этгээдийн тухай тэмдэглэл”, “Шүүхийн мэдэгдэх хуудас”-нд тухайн шүүх хуралдааныг даргалсан эсхүл илтгэсэн шүүгч гарын үсэг зурж, тоо бүртгэл хөтлөх, шилжүүлэх хөдөлгөөнийг тухайн шүүгчийн туслах гүйцэтгэж байна.

2.9. “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тухай тэмдэглэл”, “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хуулийн этгээдийн тухай тэмдэглэл”, “Шүүхийн мэдэгдэх хуудас”-ыг заасан хугацаанд цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжид хүргүүлэх ажлыг шүүхийн Тамгын газар зохион байгуулж, хяналт тавина.

**Гурав. Мэдээллийн сан бүрдүүлэх, баяжилт хийх**

3.1. Мэдээллийн сан хариуцсан нэгжийн мэдээллийн сан нь цахим болон архивын сангаас бүрдэнэ.

3.2.Цахим мэдээллийн санг анхан шатны шүүхээс ирүүлсэн “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тухай тэмдэглэл”, “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хуулийн этгээдийн тухай тэмдэглэл”, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс ирүүлсэн “Шүүхийн мэдэгдэх хуудас”, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн ялтны хувийн хэрэгт буй “Ялтны судалгааны карт” зэрэг болон холбогдох бусад материал /шийтгэх тогтоол, магадлал, шүүхийн шийдвэр, түүнийг гүйцэтгэсэн тухай тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн уучлал үзүүлсэн зарлиг, прокурорын тогтоолын эх хувь болон хуулбар/-ын мэдээллийг програм хангамжийн дагуу цахим санд оруулж бүрдүүлнэ.

3.3.Архивын сан нь анхан шатны шүүхээс ирүүлсэн шүүхийн шийдвэр, “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тухай тэмдэглэл”, “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хуулийн этгээдийн тухай тэмдэглэл”, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс ирүүлсэн Магадлал, тогтоол “Мэдэгдэх хуудас”, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн “Ялтны хувийн хэрэг”, “Ялтны судалгааны карт”, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг дуусгавар болгосон тухай шийдвэр зэргээс бүрдэнэ.

3.4. Мэдээллийн сан хариуцсан нэгжийн алба хаагчид нь “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тухай тэмдэглэл”, “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хуулийн этгээдийн тухай тэмдэглэл”, “Ялтны судалгааны карт” дахь мэдээллийг Иргэний бүртгэл, мэдээллийн төвийн мэдээллийн сантай тулгаж, цахим санд оруулан, цаасан хэлбэрээр архивын хадгалалтын стандартад нийцүүлэн “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тухай тэмдэглэл”-ийг нэрийн эхний үсгийн дагуу цагаан толгойн үсгийн дарааллаар, “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хуулийн этгээдийн тухай тэмдэглэл”-ийг цахим санд шивсэн огноогоор дараалуулан зориулалтын шүүгээнд байрлуулна.

3.5. Хүн, хуулийн этгээд нь хуурамч буюу өөр овог, нэр, улсын бүртгэлийн дугаар, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаараар урьд эрүүгийн хариуцлага хүлээсэн нь тогтоогдсон тохиолдолд холбогдох бичиг баримтыг үндэслэн, жинхэнэ овог, нэр, улсын бүртгэлийн дугаар, нэрийг залруулж бичих ба өмнөх эрүүгийн хариуцлага хүлээсэн тухай тэмдэглэлийг хамт үдэж хавсаргана.

3.6. Архивын санд иргэн, хуулийн этгээдэд холбогдох 2 буюу түүнээс дээш тооны эрүүгийн хариуцлага хүлээсэн тухай тэмдэглэл, “Ялтны судалгааны карт” байгаа тохиолдолд хүний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, биеийн байцаалт, бусад баримт, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар, нэр, регистрийн дугаар, бусад баримтыг нягтлан үзсэний дараа нэгтгэн үдэж, байрлуулна.

3.7. Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн гадаадын иргэн, хуулийн этгээдийн “Эрүүгийн хариуцлага хүлээсэн тухай тэмдэглэл”-ийг болон гадаад улсад гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн талаарх шүүхийн шийдвэрийг үндэслэн “Эрүүгийн хариуцлага хүлээсэн тухай тэмдэглэл”-ийг нэг хувь бичиж, түүнд үндэслэл болгосон баримт бичгийг хавсарган архивын санд тусад нь шүүгээнд байрлуулна.

3.8. Эрүүгийн хариуцлага хүлээсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүний овог, нэр, хуулийн этгээдийн нэрийг лавлагааны цахим санд энэ журмын 2.3-д заасны дагуу гадаад буюу латин, кирил үсгээр бичигдсэн байдлаар нь оруулах бөгөөд лавлагаа олгохдоо аль алианаар нь шалгана.

3.9. “Ялтны хувийн хэрэг”-ийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги хариуцан нээнэ. “Ялтны хувийн хэрэг”-ийн бүрдэлд шүүхийн шийтгэх тогтоол, ялтны биеийн дэлгэрэнгүй байцаалт, цээж зураг, засрал хүмүүжлийн тодорхойлолт, бүх хурууны болон алганы хээний дардас бүхий маягт, шүүхийн магадлал, хорих болон хорихоос бусад төрлийн ял эдэлж байсан хугацааны хөдөлгөөнийг бичсэн “Ялтны судалгааны карт” зэрэг байна.

3.10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь архивын нэгжийг бүрдүүлэхэд тавигдах шаардлагад нийцүүлэн “Ялтны хувийн хэрэг”-ийг хавтаслаж, товъёоглон ялтны суллагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг дуусгавар болгосон тухай шийдвэрийг 10 хоногийн дотор цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжид хүргүүлнэ.

3.11. Мэдээллийн сан хариуцсан нэгж нь “Ялтны хувийн хэрэг”-ийг хүлээн авч, бүрдлийг нягтлан, архивын дугаар олгож, архивын хадгалалтын стандартын дагуу архивт байршуулна.

3.12. Мэдээллийн сан хариуцсан нэгжийн алба хаагчид нь эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн тухай тэмдэглэлд бичигдсэн зүйлийн дутуу мэдээллийг нөхөх, нэмэх, хуучирч муудсан, гэмтсэн, урагдсаныг засварлах үүрэг хүлээнэ.

### **Дөрөв. Мэдээлийн сангаас лавлагаа олгох үндэслэл**

4.1. Цагдаагийн байгууллага нь Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.10 дахь заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/195 дугаар тушаалаар батлагдсан “Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, шинжлэн үнэлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа олгох журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор болон хууль тогтоомжийн хүрээнд хүн, хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг судлан үзэх эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтээр лавлагааг “Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас” болон албан бичгээр, ял шийтгэлтэй байгаа эсэх лавлагааг хүнд “Тодорхойлолт”-оор олгоно. */Эрх бүхий байгууллагын жагсаалтыг уг тушаалын долоодугаар хавсралтад заасан/.*

4.2. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь хүн, хуулийн этгээдийг өмнө нь эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг “Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас”-аар шалгуулах бол шалгуулж буй хүний иргэний цахим үнэмлэх, төрсний гэрчилгээ, эсхүл иргэний бүртгэлийн байгууллагаас олгосон тухайн хүний гэрэл зураг бүхий лавлагааг үндэслэж, ургийн овог, эцэг /эх/-ийн болон өөрийнх нь нэр, төрсөн он, сар, өдөр, хүйс, регистрийн дугаар, төрсөн газар, боловсрол, мэргэжил, төгссөн сургууль, эрхэлж байсан ажил зэргийг, шалгуулж буй хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, эсхүл улсын бүртгэлийн байгууллагын лавлагааг үндэслэн улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар, нэр, хариуцлагын хэлбэр, байгуулагдсан огноо, үндсэн үйл ажиллагааны чиглэл, хаяг зэргийг гүйцэд, гаргацтай бичиж, хариуцсан даргаар хянуулан гарын үсэг зуруулан тэмдэг дарж баталгаажуулсан байна.

4.3 Албан бичгээр шалгуулах бол хүн, хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгуулах эрх зүйн үндэслэл болон шалгуулж буй хүний ургийн овог, эцэг /эх/-ийн болон түүний нэр, хүйс регистрийн дугаарын мэдээлэл, хуулийн этгээдийн оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар, байгуулагдсан огноо зэргийн мэдээллийг бүрэн гүйцэд, гаргацтай бичсэн байх шаардлага тавигдана.

4.4. Шалгуулж буй хүн, хуулийн этгээдийн үндсэн болон холбогдох бусад мэдээллүүд нь эргэлзээтэй байвал бүртгэлийн байгууллагын лавлагааг заавал авч, “Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас” болон албан бичигт хавсаргаж ирүүлнэ.

4.5. Энэ журмын 4.1 дэх хэсэгт заасан байгууллага, албан тушаалтан нь “Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас” болон албан бичгийг өөрийн биеэр болон эсхүл цагдаагийн байгууллагын шуудан, факс, мэдээллийн нэгдсэн сүлжээгээр мэдээллийн сан хариуцсан нэгжид болон тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүргүүлэх бөгөөд “Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас”, албан бичиг нь энэ журмын 4.2, 4.3 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд лавлагааг олгохгүй буцаан хүргүүлнэ.

4.6. Мэдээллийн сан хариуцсан нэгжээс иргэнд ял шийтгэлтэй эсэх лавлагааг “Тодорхойлолт”-оор олгохдоо тухайн хүний иргэний үнэмлэх болон түүнтэй адилтгах бичиг баримтыг нь үндэслэн лавлагаа авах зорилгыг тодруулж, цахим сангаас шалган ял болон албадлагын арга хэмжээ авагдаж байсан боловч түүнийг эдэлж дууссан бол “Ялгүй”, дуусаагүй тохиолдолд “Ялтай” гэж лавлагааг гаргаж өгнө.

4.7. Ял шийтгэлтэй эсэх “Тодорхойлолт” авах хүн биечлэн ирэх боломжгүйгээс */гадаадад оршин суугаа, өндөр настай, өвчтэй г,м/* бусдад итгэмжлэл олгосон бол итгэмжлэл болон итгэмжлэгдсэн хүний иргэний үнэмлэх, бичиг баримтыг шалгаж лавлагаа олгож болно.

### **Тав. Лавлагаа олгох үйл ажиллагаа**

5.1. Мэдээллийн сан хариуцсан нэгжийн алба хаагч болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтний албан тушаалыг эрхэлж байгаа алба хаагчид нь эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн “Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас” болон албан бичгийг үндэслэн хүн, хуулийн этгээдийн мэдээллийг сангаас шалгаад:

а/ “Урьд эрүүгийн хариуцлага хүлээж байсан бол хэзээ, аль шүүхийн, хэддүгээр шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсгээр эрүүгийн хариуцлага хүлээж, хэзээ ямар үндэслэлээр, эрүүгийн хариуцлага хүлээж дууссан тухай мэдээллийг анх ял шийтгүүлснээс эхлэн, сүүлчийн шийтгэлийг хүртэл дэс дарааллаар бичиж өгнө.

“Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас”-аар шалгасан бол /Шалгасан газар, хэлтсийн нэр/ шалгав.” гэсэн дардас дарж, шалгасан алба хаагч гарын үсэг зурж, он, сар, өдрийг бичиж тэмдэглэнэ.

б/ Урьд эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй бол “Мэдээллийн санд бүртгэгдээгүй байна” гэсэн хариу өгөх ба “Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас”-аар шалгасан бол “Мэдээллийн санд бүртгэгдээгүй” гэсэн дардас дарж, шалгасан алба хаагч гарын үсэг зурж, он, сар, өдрийг бичиж тэмдэглэнэ.

5.2. “Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас”-аар шалгуулж буй хүн, хуулийн этгээдийн үндсэн болон бусад мэдээлэл нь тодорхой бус, зөрүүтэй байвал энэ тухай үндэслэл бүхий тайлбар хийж, “Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас”-д тэмдэглэл үйлдэнэ.

5.3. Цахим сангийн мэдээлэл бүрэн бус, үнэн, зөв эсэх нь эргэлзээтэй байвал нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын мэдээлэл судалгаа хариуцсан алба хаагч нь Мэдээллийн сан хариуцсан нэгжтэй холбогдон тодруулга хийж, Мэдээллийн сан хариуцсан нэгжийн алба хаагч нь архивын санд байгаа мэдээлэл, баримт материалаас магадлан мэдээллийг тодруулж хариу өгнө.

5.4. Мэдээллийн сан хариуцсан нэгж нь эрх бүхий байгууллага албан тушаалтнаас ирүүлсэн үндэслэл бүхий албан бичгийг үндэслэн “Ялтны хувийн хэрэг”-ээс шаардлагатай баримт, материалыг хуулбарлан өгч болно.

5.5. Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн “Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас” болон албан бичгээр авч байгаа лавлагааг үнэ төлбөргүй өгнө.

5.6. Энэ зааврын 4.6, 4.7-д заасан иргэний хүсэлтийн дагуу лавлагааг “Тодорхойлолт”-оор олгоно.

“Тодорхойлолт” нь олгосон өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.  
(Тодорхойлолтын загварыг уг тушаалын наймдугаар хавсралтад заасан).

5.7. Ял шийтгэлтэй байгаа эсэх Тодорхойлолт авах иргэн Архивын ерөнхий газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/168 дугаар тушаалын 2.1.11 дэх хэсэгт заасны дагуу үйлчилгээний төлбөр төлөх бөгөөд үйлчилгээний хураамжыг Төрийн сан дахь Цагдаагийн ерөнхий газрын 100900012034 тоот дансанд тушааж баримтыг Мэдээллийн сан хариуцсан нэгжийн алба хаагчид өгч Тодорхойлолт авна.

5.8. “Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас”-аар өгөх лавлагааг ажлын 2 хоногийн дотор багтаан шалгаж хариу өгөх бөгөөд олон хүн, хуулийн этгээдийн мэдээллийг гаргуулахаар ирүүлсэн тохиолдолд тухайн хүсэлт ирүүлсэн албан тушаалтанд мэдэгдэж хугацааг тогтооно.

5.9. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээ, факсаар солилцсон лавлагааны материалын эх хувийг шуудангаар буцаана.

5.10. Цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээ, факсаар явуулсан Мэдээллийн сан хариуцсан нэгжийн хариуг хүлээн авсан цагдаагийн байгууллагын дарга нь түүнд энэ тухай тэмдэглэл хийж, байгууллагын тамга, тэмдэг дарж баталгаажуулна.

## Зургаа. Хориглох зүйл

6.1. “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тухай тэмдэглэл”, “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хуулийн этгээдийн тухай тэмдэглэл”, “Ялтны хувийн хэрэг”, “Ялтны судалгааны карт”-ыг бусдад шилжүүлэхийг хориглоно.

6.2. Мэдээллийн сан хариуцсан нэгжийн алба хаагч эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн мэдээлэл, материалын нууцлалыг чанд сахиж ажиллахын зэрэгцээ, Сангийн эрхлэгчийн зөвшөөрөлгүйгээр лавлагааны сангийн байранд гадны хүн оруулахыг хориглоно.

6.3. Мэдээллийн сан хариуцсан нэгжийн алба хаагч болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын мэдээлэл судалгаа хариуцсан алба хаагчаас бусад цагдаагийн алба, нэгж бусдад эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн тухай лавлагаа олгохыг хориглоно.

### **Долоо. Хариуцлага**

7.1. Энэ журмыг мөрдөж ажиллаагүй, төрийн алба хаагчийн ёс зүй зөрчсөн, ажлын хариуцлага, сонор сэрэмж алдсан шүүх, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, алба хаагчдад холбогдох хууль тогтоомжид зааснаар хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---



Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2017 оны ..... дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт

### ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭСЭН ХҮНИЙ ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

Эрүүгийн хэргийн дугаар: \_\_\_\_\_

1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан байгууллага: \_\_\_\_\_
2. Яллагдагчийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хүйс : \_\_\_\_\_

*/Гадаадын иргэн, харъяалалгүй этгээдийн овог, нэрийг түүний албан ёсны бичиг баримтад бичигдсэн байдлаар бичихийн зэрэгцээ кирил үсгээр хөрвүүлж бичнэ./*

3. Төрсөн огноо, газар: \_\_\_\_\_
4. Иргэний харьяалал: \_\_\_\_\_
5. Үндсэн захиргаа: \_\_\_\_\_
6. Оршин суух хаяг: \_\_\_\_\_
7. Регистрийн дугаар: \_\_\_\_\_ 8. Утасны дугаар \_\_\_\_\_

Тэмдэглэл үйлдсэн: \_\_\_\_\_  
/албан тушаал, цол, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, гарын үсэг/

- 9.. Шийдвэрлэсэн шүүх: \_\_\_\_\_
10. Шийтгэх /цагаатгах/ тогтоолын \_\_\_\_ он \_\_\_\_ сар \_\_\_\_ өдөр, Дугаар \_\_\_\_\_
11. Шийтгэх /цагаатгах/ тогтоолын хэлбэр, шийдвэрлэсэн байдал: \_\_\_\_\_
12. Хуулийн зүйлчлэл: \_\_\_\_\_
13. Шүүхээс шийдвэрлэсэн байдал :/Ялын төрөл, хэмжээ, нэмж нэгтгэсэн, тэнссэн, хойшлуулсан зэргийг товч, тодорхой бичнэ./

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

Шүүхийн тамга

Тэмдэглэл үйлдсэн шүүгч: \_\_\_\_\_  
/гарын үсэг, нэр/

Анхааруулга

Нэг. Мөрдөгч, хэрэг бүртгэх эрх бүхий алба хаагч нь:

1. Эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдсан иргэний цахим үнэмлэх болон түүнтэй адилтгах баримт бичиг /төрсний гэрчилгээ, иргэний бүртгэлийн байгууллагын лавлагаа зэрэг/-ыг үндэслэх.
2. Сүүлийн сард авахуулсан цээж зургийг наах.
3. 1-8 дугаар асуултын хариуг гаргацтай хөтөлж бичих.
4. Яллагдагчаар татагдсан гадаадын болон харъяалалгүй иргэнтэй холбоотой хэргийн ял шийтгэлийн тэмдэглэл хөтлөхдөө түүний гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг дээрх гадаад буюу латин үсгээр бичигдсэн овог, нэрийг бичихийн зэрэгцээ кирил үсгээр хөрвүүлж бичнэ.
5. Ял шийтгэлийн тэмдэглэлийг А5 хэмжээтэй батлагдсан загварын дагуу хийгдсэн хэвлэмэл хуудсанд бичиж байх. /200гр-ын цаас/

Хоёр. Хэргийг шийдвэрлэсэн шүүгч нь:

1. Тухайн иргэний биеийн байцаалтын үнэн зөвийг магадлах.
2. 9-13 дугаар асуултын хариуг гүйцэд гаргацтай бичсэн эсэхийг нягтлан шалгах.
3. Шүүхийн шийтгэх тогтоол гарснаас хойш 5 хоногт багтаан Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн хуулийн этгээдийн тухай тэмдэглэлийг Цагдаагийн төв байгууллагын Мэдээллийн сан хариуцсан нэгжид хүргүүлнэ
4. Гарын үсгийн тайллыг бичих.



## ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭСЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

Эрүүгийн хэргийн дугаар: \_\_\_\_\_

1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан байгууллага: \_\_\_\_\_
2. Байгууллага, аж ахуйн нэгжийн нэр: \_\_\_\_\_  
/Гадаад улсын хуулийн этгээдийн нэрийг албан ёсны бичиг баримтад бичигдсэн байдлаар давхар бичнэ/
3. Улсын бүртгэлийн дугаар: \_\_\_\_\_
4. Регистрийн дугаар: \_\_\_\_\_
5. Байгуулагдсан огноо: \_\_\_\_\_
6. Үйл ажиллагааны үндсэн чиглэл: \_\_\_\_\_
7. Хариуцлагын хэлбэр: \_\_\_\_\_
8. Хаяг, /Утас/: \_\_\_\_\_

9. Үүсгэн байгуулагч, хувь эзэмшигч, шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтны мэдээлэл:  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

10. Аль улсын харьяалалтай эсэх: \_\_\_\_\_
11. Өмчийн хэлбэр:  төрийн  төрийн бус  хувийн  гадаадын хөрөнгө оруулалттай  хамтарсан хөрөнгө оруулалттай,

Тэмдэглэл үйлдсэн: \_\_\_\_\_  
/албан тушаал, цол, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, гарын үсэг/

12. Шийдвэрлэсэн шүүх: \_\_\_\_\_
13. Шийтгэх /цагаатгах/ тогтоолын \_\_\_\_\_ он \_\_\_\_\_ сар \_\_\_\_\_ өдөр, Дугаар \_\_\_\_\_
14. Шийтгэх /цагаатгах/ тогтоолын хэлбэр, шийдвэрлэсэн байдал: \_\_\_\_\_
15. Хуулийн зүйлчлэл: \_\_\_\_\_
16. Шүүхээс шийдвэрлэсэн байдал : /Ялын төрөл, хэмжээг товч, тодорхой бичнэ./  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

Шүүхийн тамга

Тэмдэглэл үйлдсэн шүүгч: \_\_\_\_\_  
/гарын үсэг, нэр/

Анхааруулга

Нэг. Мөрдөгч, хэрэг бүртгэх эрх бүхий алба хаагч нь:

Эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, лавлагаа зэргийг үндэслэн, 1-11 дугаар асуултын хариуг үнэн зөв гаргацтай хөтөлж бичнэ.

Хоёр. Хэргийг шийдвэрлэсэн шүүгч нь:

Тухайн хуулийн этгээдийн мэдээллийг үнэн зөвийг магадлаж, Шүүхийн шийтгэх тогтоол гарснаас хойш 5 хоногт багтаан Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тухай тэмдэглэлийн 12-16 дүгээр асуултын хариуг гүйцэд гаргацтай бичсэн эсэхийг нягтлан шалган, гарын үсэг зурж Цагдаагийн төв байгууллагын Мэдээллийн сан хариуцсан нэгжид хүргүүлнэ.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2017 оны ..... дугаар хамтарсан тушаалын дөрөвдүгээр хавсралт

### ШҮҮХИЙН МЭДЭГДЭХ ХУУДАС

он сар өдөр

Дугаар

Аймаг/хотын нэр

\_\_\_\_\_овогтой \_\_\_\_\_ нь /РД: \_\_\_\_\_ / иргэн/хуулийн этгээд нь \_\_\_\_\_  
(доогуур зурах)

оны \_\_\_ сарын \_\_\_ -ны өдөр \_\_\_\_\_ шүүхийн \_\_\_ дугаар шийтгэх /цагаатгах/  
тогтоолоор Эрүүгийн хуулийн \_\_\_\_\_ зүйлийн \_\_\_\_\_-д зааснаар

\_\_\_\_\_ эрүүгийн хариуцлага хүлээсэн.

Энэ шийтгэх /цагаатгах/ тогтоолд \_\_\_\_\_ шүүхийн \_\_\_ оны \_\_\_ сарын \_\_\_ ны  
өдрийн \_\_\_\_\_ дугаар магадлал, \_\_\_\_\_ /тогтоол/-аар

өөрчлөлт оруулсан болохыг мэдэгдэе.

ТАЙЛБАР: Шүүхийн мэдэгдэх хуудсыг илтгэсэн шүүгч 3 хувь бичиж, нэг хувийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад, нэг хувийг цагдаагийн төв байгууллагын Мэдээллийн сан хариуцсан нэгжид үлдэх хувийг шүүхийн бичиг хэрэгт бүртгэж, хадгална.

\_\_\_\_\_ шүүхийн шүүгч \_\_\_\_\_

Тамга

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн  
ерөнхий зөвлөлийн даргын 2017 оны  
..... дугаар хамтарсан  
тушаалын тавдугаар хавсралт

**ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЖ БАЙСАН ЭСЭХИЙГ ШАЛГАХ ХУУДАС**  
**/Иргэн/**

.....оны ..... сарын ..... өдөр

.....аймаг, хот

1	Ургийн овог	
2	Эцэг /эх/-ийн нэр	
3	Нэр	
4	Төрсөн, он, сар, өдөр	
5	Төрсөн аймаг, хот, сум, дүүрэг	
6	Хүйс	
7	Яс үндэс	
8	Боловсрол, мэргэжил	
9	Төгссөн сургууль, эрхэлж байсан ажил  /он дарааллаар бичнэ/	
10	Регистрийн дугаар	
11	Урьд эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх	

Шалгасан тухай

тэмдэглэл: \_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

ГҮЙЦЭТГЭСЭН: ..... хэлтэс /тасаг/-ийн.....  
албан тушаалтай .....цолтой...../ /

ХЯНАСАН:.....хэлтэс /тасаг/-ийн дарга ..... цолтой...../ /

ШАЛГАСАН:..... ажилтан /цол, нэр/..... / /

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн  
ерөнхий зөвлөлийн даргын 2017 оны  
..... дугаар хамтарсан тушаалын  
зургаадугаар хавсралт

**ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЖ БАЙСАН ЭСЭХИЙГ ШАЛГАХ ХУУДАС**  
**/Хуулийн этгээд/**

.....оны ..... сарын ..... өдөр

..... аймаг, хот

1	Хуулийн этгээдийн нэр	
2	Улсын бүртгэлийн дугаар	
3	Регистрийн дугаар	
4	Байгуулагдсан огноо	
5	Үйл ажиллагааны үндсэн чиглэл	
6	Хариуцлагын хэлбэр	
7	Хаяг	
8	Шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтны мэдээлэл	
9	Аль улсын харьяалалтай эсэх	
10	Өмчийн хэлбэр	
11	Урьд эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх	

Шалгасан тухай

тэмдэглэл: \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

ГҮЙЦЭТГЭСЭН: ..... хэлтэс /тасаг/-ийн.....  
албан тушаалтай .....цолтой...../ /

ХЯНАСАН:.....хэлтэс /тасаг/-ийн дарга ..... цолтой...../ /

ШАЛГАСАН:..... ажилтан /цол, нэр/..... / /

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн  
ерөнхий зөвлөлийн даргын 2017 оны  
..... дугаар хамтарсан  
тушаалын долоодугаар хавсралт

ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА  
ХҮЛЭЭЖ БАЙСАН ЭСЭХИЙГ СУДЛАН ҮЗЭХ ЭРХ БҮХИЙ  
БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

1. Шүүхийн байгууллага
2. Прокурорын байгууллага
3. Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 5.1.2, 5.1.3 дахь хэсэг, 7, 8 дугаар зүйлд заасан албан тушаалд томилох төрийн байгууллагууд
4. Монгол банк
5. Авлигатай тэмцэх газар
6. Санхүүгийн зохицуулах хороо
7. Бүх шатны засаг дарга нар
8. Улсын бүртгэлийн байгууллага
9. Цагдаагийн байгууллага
10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага
11. Шүүхийн шинжилгээний байгууллага
12. Хүүхдийн эрхийг хамгаалах төрийн болон төрийн бус байгууллага
13. Монгол Улсад суугаа Гадаад Улсын Элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн болон Консулын газар
14. Олон Улсын зэрэглэлтэй нисэх буудал
15. Монголын хуульчдын холбоо
16. Хууль тогтоомжоор эрх олгосон бусад байгууллага

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн  
ерөнхий зөвлөлийн даргын 2017 оны  
..... дугаар хамтарсан  
тушаалын наймдугаар хавсралт

/Сери дугаар/



**МОНГОЛ УЛС**  
**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**  
**ТОДОРХОЙЛОЛТ**

.....оны.....сарын.....өдөр

Улаанбаатар хот

Регистрийн дугаар .....

..... овогтой .....

**Ялгүй /Ялтай** байна.



Та тодорхойлолт авснаас 24 цагийн дараа  
[www.service.police.gov.mn](http://www.service.police.gov.mn) цахим хуудсыг ашиглан  
..... дугаараар шалгах боломжтой.

Энэхүү тодорхойлолт нь олгогдсон өдрөөс хойш 45 хоногийн  
хугацаанд эх хувиараа хүчин төгөлдөр байна.

Монгол Улсын Засгын газрын хэрэгжүүлэгч агентлаг-  
Архивын ерөнхий газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 09-ний  
А/168 дугаар тушаалын 2.1.11-д заасны дагуу архиваас үзүүлэх  
төлбөрт үйлчилгээний хураамжинд 500 төгрөг хураав.

**МЭДЭЭЛЭЛ НЭГТГЭН БОЛОВСРУУЛАХ**  
**ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА**

/Албан тушаал, цол/

/Гарын үсэг/

/Нэр/